

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ 01/2022

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “БидиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
2. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

БИДИСЕК ҮЦК ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙГДСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

БиДиСЕК ҮЦК ХК нь 2021 онд 1 их наяд төгрөгийн арилжаа гүйцэтгэсэн нь Монголын Хөрөнгийн Биржийн нийт арилжааны 38 хувийг дангаар бүрдүүлсэн үзүүлэлт байна. Компани нь цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан онлайн арилжааны системийг сайжруулан идэвхжүүлж, харилцагчиддаа саадгүй үйлчилгээгээ авах боломжийг бүрдүүлэн онлайн харилцагчийн тоог 127 хувиар, онлайн хэлцлийн тоог 9 дахин нэмэгдүүлжээ. Мөн хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах вэб аппликэйшнийг өөрсдөө хөгжүүлснээр 6 хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

Компани нь олон улсын SAXO банкны Монгол улс дахь албан ёсны цор ганц дамжуулагч брокерын хувьд SAXO банкаар дамжуулан 6.4 сая долларын арилжаа хийсэн нь өмнө жилийн мөн үетэй харьцуулахад 103 хувийн өсөлтийг үзүүлжээ.

БиДиСЕК ҮЦК ХК нь тайлант жилд Монгол улсад давхар бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах ажиллагаанд андеррайтераар ажиллаж, 14.25 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Мөн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн зах зээл дэх хамгийн өндөр дүн буюу 2 их наяд төгрөг хүртэлх нээлттэй өрийн бичиг гаргах ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар ажиллаж байна. Түүнчлэн Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат хэлбэртэй байхаар зохицуулагдсан бөгөөд үүнтэй холбоотой банкны салбарын тэргүүлэгч болох ХААН Банк ХХК-ийн IPO ажиллагаанд андеррайтераар сонгогдсон. Энэхүү ажиллагааны хүрээнд өнгөрсөн жил Монголбанканд нээлттэй хувьцаат компани болох төлөвлөгөөгөө хүргүүлэн батлуулж, анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох бэлтгэл ажлаа хийж байна.

Гадаад болон дотоодын санхүү, хөрөнгийн зах зээл дээр олон жилийн туршлагатай зөвлөхүүдийг урьж ажиллуулж, компанийн мэргэжилтнүүдтэй харилцан туршлага солилцон томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

БиДиСЕК ҮЦК ХК нь 2021 онд 4.2 тэрбум төгрөгийн нийт орлого, 1.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдээ нэгж хувьцаанд 50 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Иймд БиДиСЕК ҮЦК ХК-ийн гүйцэтгэх удирдлага нь 2021 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, зөвлөмжийг амжилттай хэрэгжүүлсэн тул үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн Төлөөлөн Удирдах Зөвлөл дүгнэлээ.

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ 02/2022

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.13 дахь заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “БидиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг нийт 58,600,000 төгрөгөөр баталсугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

№ 03/2022

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “БидиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:

Ердийн гишүүдэд:

1. Д.Даянбилгүүн
2. Б.Лхагвадорж
3. Н.Батгэрэл
4. Улуч Бингол
5. О.Уранбайгал

Хараат бус гишүүдэд

1. Хитоши Тани
2. Б.Энхбаяр
3. Д.Амгаланбаяр
4. О.Лхагвасүрэн

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/